



# PROUVÉ

КАРЬЕР  
ТӨЛӨВЛӨЛТ



3  
КЛУБ



36%

#ЭХЛЭЛ

Партнер Клуб  
Амбассадор Клуб  
Элит Амбассадор Клуб  
|2024 10



# PROUVÉ БИЗНЕСИЙН КАРЬЕРАА ХЭРХЭН ХӨГЖҮҮЛЭХ ВЭ?

Энэхүү **Карьер Төлөвлөлт** танд нэмэлт пассив орлоготой болох боломжийг ойлгуулж, МӨРӨӨДӨЛ-өө бодит болгоход тань туслах болно.

## ТОВЧ АГУУЛГА

ТА ЗАРДЛАА ХЭМНЭХИЙГ ХҮСЭЖ БАЙНА УУ .....	4
ТА НЭМЭЛТ ПАССИВ ОРЛОГОТӨЙ БОЛОХЫГ ХҮСЭЖ БАЙНА УУ .....	5
ТА ӨӨРИЙН БИЗНЕСТЭЙ БОЛОХЫГ ХҮСЭЖ БАЙНА УУ .....	6
ТА ТЭРБУМТАН БОЛЖ САНХҮҮГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНД ХҮРЭХИЙГ ХҮСЭЖ БАЙНА УУ .....	15

# ТАНЫГ АМЖИЛТАНД ХҮРЭХЭД БИД ТУСЛАНА.

Бид хүсэл зорилгоороо нэгдсэн баг хамт олныг бүрдүүлж, эрүүл эко хэрэглээг сурталчлан аз жаргалтайгаар ажиллаж, амжилтанд хүрдэг. Энэхүү бизнесээ эрхлэхдээ бид бие даасан байдлаар өөрийн мөрөөдлийн төлөө эрх чөлөөтэйгөөр ажилладаг. ТА НЭМЭЛТ ПАССИВ ОРЛОГО-той болох төлөвлөгөө, олон төрлийн урамшуулуудыг энэхүү КАРЬЕР ТӨЛӨВЛӨЛТ-өөс мэдэж авна.

Бидний санал болгож буй өдөр тутмын өргөн хэрэглээний бүтээгдэхүүнүүд нь эх дэлхийгээ, гэр бүлээ хайрладаг хүн бүрт таалагддаг өндөр сэтгэл ханамжийг авчрах бүтээгдэхүүн юм. Бүтээгдэхүүнүүд маань эмч, эрдэмтэн судлаачдын багийн олон жилийн судалгаа шинжилгээ туршилтын үр дүнд шинэлэг дэвшилтэт био технологиор бүтээгдсэн. Франц эфирийн тосны тансаг үнэрийг агуулсан төдийгүй таны ажлыг бүрэн хөнгөвчилж цагийг хэмнэдэг нь манай бүтээгдэхүүний бас нэгэн давуу тал бөгөөд хэрэглэгчийн таашаалд бүрэн нийцдэг нь бидний бизнесийн гол хөдөлгүүр юм. Мөн зах зээлд өрсөлдөхүйц бодит үнэ шуурхай үйлчилгээг санал болгож байдагтаа бид баяртай байна.

Та бидэнтэй нэгдсэнээр санхүүгийн эрх чөлөөнд хүрэх боломжоо нээж, өөрийн өдөр тутмын хэрэгцээгээ хангах явцдаа нэмэлт ОРЛОГО-той болдогт бидний бизнесийн бас нэгэн онцлог оршиж байгаа юм.

Та ЭРҮҮЛ ЭКО бүтээгдэхүүн хэрэглэнэ, хувь хүний хувьд хөгжлийн ШИНЭ ТҮВШИН-д хүрнэ, нэмэлт ПАССИВ орлоготой болж санхүүгийн эрх чөлөөнд хүрч томоохон багийн ЛИДЕР болно.

PROUVE БИЗНЕС нь таны "САЙН САЙХАН АМЬДРАЛ"-ийн түнш байх болно.

Prouvé-ийн хамт олноос

## БИДНИЙ ҮНЭТ ЗҮЙЛС ЮУ ВЭ?

- ♥ *#Мударга байдал, өндөр ёс зүй*
- ♥ *#Итгэл үнэмшил*
- ♥ *#Дэвшилтэт технологи, хялбар шийдлүүд*
- ♥ *#Багийн амжиллагаа*

## ХЭРХЭН ЗӨВ ХУДАЛДАН АВАЛТ ХИЙЖ МӨНГӨӨ ХЭМНЭХ ВЭ?

Мерлин Монро: “Аз жаргал мөнгөнд биш, түүгээр худалдан авалт хийхэд оршино” гэж хэлсэн байдаг. Та үүнтэй санал нийлэх байх. Таныг ухаалгаар худалдан авалт хийхэд бид тусалж ашигтай саналуудыг тавьж, таны цаг хугацааг хэмнэх болно. Та бүтээгдэхүүнээ онлайнаар болон утсаар захиалж, хүссэн газраа хурдан шуурхай хүргүүлж аваарай. Үүгээр зогсохгүй та худалдан авалт хийх бүртээ зардлаа **ОРЛОГО** болгох боломжтой.

### 👉 Хэрхэн ажилладаг вэ:

Партнер бүтээгдэхүүн бүр дээр 40%-ийн үнийн хөнгөлөлт эдэлнэ.

Таны худалдан авалт	Каталоги үнэ	Партнер үнэ (хөнгөлөлттэй үнэ)	Таны хэмнэлт
Аяга таваг угаагч гель	39 200₮	28 000₮	11 200₮
Өнгөт угаалгын гель 1000 мл	50 400₮	36 000₮	14 400₮
Шил толь цэвэрлэгч, цанаталтын эсрэг үйлчилгээтэй 500мл	36 400₮	26 000₮	10 400₮
<b>Нийт:</b>	126 000₮	90 000₮	36 000₮
<b>Жилд:</b>			432 000₮

Хэмнэсэн 432 000 төгрөгөө та мөрөөдлөө биелүүлэхэдээ ашиглаарай.

Би хэмнэлт хийснээрээ...

---

---

---

Би хэмнэсэн мөнгөөрөө...

---

---

---

### Үнэт зөвлөгөө:



Биднийг сошиал болон вэб сайт дээр байнга дагаарай. Та бидний санал болгож буй бусад урамшууллын талаарх мэдээллийг тогтмол авч илүү ихийг хэмнэх боломжтой.

## ХЭРХЭН СУРТАЛЧИЛЖ, НЭМЭЛТ ОРЛОГОТОЙ БОЛОХ ВЭ?

Бид таны өдөр тутмын ажлыг хөнгөвчлөх таашаалд тань нийцэх эко бүтээгдэхүүнийг өрсөлдөхүйц бодит үнээр санал болгодог бөгөөд та хөнгөлөлттэй үнээр худалдан авч, эцсийн хэрэглэгчид каталоги үнээр буюу 40%-ийн ашигтай үнээр борлуулах боломжтой. Ингэснээр та бас нэгэн нэмэлт орлого болох шууд ашгийг хүртэх болно.

### Хэрхэн ажилладаг вэ:

Prouvé брэндийн бүтээгдэхүүнийхээ давуу талыг найз нөхөд бусад хүмүүст танилцуулан сурталчилж, худалдан авалт хийлгэж хэрэглэгч болгоорой.

Таны худалдан авалт	Каталоги үнэ	Партнер үнэ (хөнгөлөлттэй үнэ)	Шууд ашиг
Эрдэсжүүлсэн нунтаг энгэсэг	53 200₮	38 000₮	15 200₮
Сормуусны будаг	53 200₮	38 000₮	15 200₮
Хивс буйдан угаагч шампунь	53 200₮	38 000₮	15 200₮
Үс сэргээн бэхжүүлэгч шампунь	58 800₮	42 000₮	16 800₮
<b>Нийт:</b>	218 400₮	156 000₮	62 400₮
<b>Жилд:</b>			748 800₮

Каталоги үнэ болон партнер үнэ хоорондын зөрүү нь таны шууд ашиг болсноор бас нэгэн нэмэлт орлогыг бий болгоно. Энэхүү нэмэлт орлогоо та өөртөө болон гэр бүлийн гишүүддээ Prouvé бүтээгдэхүүн худалдаж авах эсвэл өөрт хэрэгтэй бусад зүйлсээ худалдаж авахад зориулаарай.

*Би өөрийн ашиг болох ..... төгрөгөө юунд зарцуулах вэ...*

---



---



---



---



---



---

### Үнэт зөвлөгөө:

Бүтээгдэхүүнээ зээлээр борлуулахаас татгалзаарай. Та бүтээгдэхүүний захиалга авах үедээ худалдан авагчид төлбөр тооцоогоо бүрэн төлөхийг сануулаарай. Хэрэв тухайн худалдан авагч төлбөр төлөлтөө хойшлуулбал та өөр хэрэглэгчийг олоорой.



## ХЭРХЭН САНАЛ БОЛГОЖ, НЭМЭЛТ ПАССИВ ОРЛОГО ОЛОХ ВЭ?

Та Prouvé-тэй хамтарч ажиллахаар шийдсэн бол орлого олох эхний алхам тань „САНАЛ БОЛГОХ”. Сайхан ресторан, сайн засварчин, сайн эмчийг хэн нэгэнд санал болгодогтой яг адил. Энэ нь баталгаатай, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгодог маркетингийн (MLM) шилдэг аргуудын нэг юм.

### 👉 Хэрхэн ажилладаг вэ:

Та өөрийн танил найз нөхөд, өмнөх худалдан авагч, одоо байгаа хэрэглэгч нараасаа PROUVE-гийн партнер болж дуртай бүтээгдэхүүнээ өөрөө захиалан авах хүсэлтэй байгаа эсэхийг асуугаарай. Хэрэв тэд хүсвэл PROUVE партнер болоход нь тусалж бүртгүүлснээр тэд партнер болж та спонсор нь болно. Ингэснээр та өөрийн багаа бүрдүүлж эхэлнэ.

Каталоги дахь бүтээгдэхүүн тус бүр оноотой байдаг. Таныг худалдан авалт хийх бүрт эдгээр оноо нь таны дансанд нэмэгдэн тухайн сардаа хуримтлагддаг. (та өөрийн оноогоо [www.mn.prouve.com](http://www.mn.prouve.com) вэб сайтад өөрийн эрхээр нэвтрэн харах боломжтой).

Таны багт байдаг партнерууд худалдан авалт хийх бүрт тухайн бүтээгдэхүүний оноо тэдэнд болон танд ч орно. Сар бүр таны болон таны багийн партнеруудын худалдан авалтын оноо нь таныг болон таны багийн гишүүдийг Prouvé-гийн аль нэгэн амжилтын түвшин, цолонд хүргэнэ. Та өөрийн **амжилтын түвшин, хувийн худалдан авалт, багийн бүтцийн эргэлт** (таны багийн партнеруудын худалдан авалтын нийт оноо) **зэргээс хамаарсан мөнгөн урамшууллыг сар бүр авах боломжтой.**

### Санамж!

Өөрийн Партнер дугаар дээр хамгийн багадаа хувийн худалдан авалтын 100 оноо цуглуулснаар та тухайн сарын мөнгөн урамшууллаа авах эрхтэй болно.



### Үнэт зөвлөгөө:

Спонсор болно гэдэг таны амжилтын эхлэл. Таны багийн партнерууд худалдан авалт хийх бүрт таны амжилтын түвшин, урамшууллыг нэмэгдүүлэн тодорхойлж байдаг.



# ТАНЫ УРАМШУУЛАЛ БОЛОН САРЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАН



**Prouvé Карьер Төлөвлөлт** нь 3 үе шаттай:

Prouvé Партнер Клуб

Prouvé Амбассадор клуб

Prouvé Элит Амбассадор Клуб

Партнер Клубын гишүүн бол таны урамшуулал нь багийн бүтцийн эргэлт, таны 1-р эгнээний партнеруудын хувийн зөрүүгээс хамааран тодорхойлогдож байдаг.

Амбассадор болон Элит Амбассадор Клубын гишүүн бол таны урамшуулал нь багийн бүтцийн эргэлтээс гадна компанийн нийт эргэлтээс мөн хамаарна. Сар бүр [www.mn.prouve.com](http://www.mn.prouve.com) вэб сайт дахь санхүүгийн тайлан хэсгээс та өмнөх сарын мэдээллүүд болон одоогийн нийт оноо мөн авах боломжтой урамшууллын хэмжээгээ хараарай.

Танд сар бүр шинэ боломжууд нээгдэнэ. Та сар бүрийн эхнээс оноо цуглуулж, амжилтын түвшин болон цолоо ахиулах боломжтой.

## Урамшуулал түүнийг ашиглах боломжууд

Та хамтын ажиллагааны гэрээ, карьер төлөвлөлт, үйлчилгээний нөхцөл зэрэгт заасан шаардлагуудыг биелүүлснээр урамшууллаа ашиглах боломжтой болно. Та өөрийн дансан дахь урамшууллаа (таны Prouvé дансан дахь орлого) [www.mn.prouve.com](http://www.mn.prouve.com) вэб сайтаар орж шалган худалдан авалтандаа шууд ашиглах боломжтой. Энэхүү дансан дахь урамшуулал нь бодогдсон өдрөөс дараа жилийн 1 дүгээр сарыг дуустал хүчинтэй байна.

Хэрэв та өөрийн Prouvé бизнесээ эхлүүлэхийг хүсвэл партнер болж ажиллан энэхүү Карьер төлөвлөлт, хамтын ажиллагааны гэрээ, үйлчилгээний нөхцөл зэрэгт заасныг хэрэгжүүлснээр мөнгөн урамшуулал буюу нэмэлт орлого олох боломжтой.



### Үнэт зөвлөгөө:








Таны багийн бүтэц зөв байх хэрэгтэй. Та өргөн төдийгүй гүн баг бүрдүүлээрэй. Гүн баг нь тогтвортой байдлыг нэмэгдүүлж, харин өргөн баг нь орлого нэмэгдүүлнэ.

## ТАНЫ КАРЬЕРЫН ҮЕ ШАТУУД

Prouvé бизнесээ эхлүүлэх үедээ бүтээгдэхүүнүүдээ худалдан авч хэрэглээд онцлог давуу талуудтай танилцсанаар Prouvé брэндийн партнер болно. Та шинээр олон хүнд бүтээгдэхүүн, бизнесийн давуу талуудыг танилцуулан урьснаар багаараа хамтдаа амжилтанд хүрэх төдийгүй та Prouvé Амбассадор болж цаашлаад таны багийн эргэлтийн оноо 2,5саяас дээш болвол та Prouvé Элит Амбассадор болох юм.

## ПАРТНЕР КЛУБД элсэхэд тавигдах шаардлагууд

Та хүмүүст бүтээгдэхүүн болон бизнесээ танилцуулан, урьж партнер болгон өөрийн бүтэц буюу баг хамт олноо бүрдүүлж эхэлснээр багийнхаа лидер спонсор нь болно. Таны багийн цуглуулах нийт оноо нь таны урамшуулалд шууд нөлөөлнө.

Багийн бүтцийн эргэлт/ багийн оноо /сард/	Таны амжилтын түвшин	Хувийн худалдан авалтын онооны доод хэмжээ /сард/	Таны амжилтын цол
300 - 1 199 99 оноо	3%	100 оноо	 Prouvé брэнд партнер
1 200 - 3 599 99 оноо	6%	100 оноо	 Prouvé брэнд партнер
3 600 - 7 199 99 оноо	9%	100 оноо	 Prouvé брэнд партнер
7 200- 11 999 99 оноо	12%	100 оноо	 Prouvé брэнд партнер
12 000 - 20 399 99 оноо	15%	100 оноо	 Prouvé брэнд партнер 1 мөнгөн*
20 400 - 29 999 99 оноо	18%	100 оноо	 Prouvé брэнд партнер 2 мөнгөн*
30,000 ба түүнээс дээш оноо	21%	100 оноо	 Prouvé брэнд партнер 3 мөнгөн*





## ДЭЛХИЙН ЭРГЭЛТИЙН НЭМЭЛТ УРАМШУУЛАЛ

Хэрэв та 15%-ийн (Prouvé брэнд партнер 1 мөнгөн ★) амжилтанд хүрсэн бол нэмэлт урамшуулалд хамрагдана. Тухайн сард таньтай ижил түвшинд хүрсэн болон багийн эргэлт 60/40 харьцааг хангасан (таны хамгийн өндөр оноотой багийн эргэлт нь таны багийн бүтцийн нийт эргэлтийн 60-аас илүү хувийг эзлэхгүй байх) нийт партнерууд нь Prouvé-ийн нийт эргэлтийн онооны 0.4%-ийг хувааж авахыг ДЭЛХИЙН ЭРГЭЛТИЙН УРАМШУУЛАЛ(ДНЭ) гэнэ. Энэхүү урамшуулал нь 18% болон 21%-ийн амжилттай партнеруудад мөн олгогдоно.

$$\text{Таны урамшуулал} = \frac{\text{Нийт эргэлтийн оноо} \times \text{Таны бүтцийн эргэлтийн оноо} \times 0.4\%}{\text{Тухайн амжилтын түвшинд хүрсэн партнеруудын нийт бүтцийн эргэлт}}$$

Багийн эргэлтийн оноо /сард/	Таны амжилтын түвшин	Хувийн худалдан авалтын онооны доод хэмжээ / сард/	Багийн харьцаа	ДЭЛХИЙН ЭРГЭЛТИЙН ХУВЬ /Болзол хангасан партнеруудад олгох нийт онооны эргэлт/
12 000 – 20 399 99 оноо	15% Prouvé брэнд партнер 1 мөнгөн★	100 оноо	60/40	0,4%
20 400 – 29 999 99 оноо	18% Prouvé брэнд партнер 2 мөнгөн★	100 оноо	60/40	0,4%
30 000 онооноос дээш	21% Prouvé брэнд партнер 3 мөнгөн★	100 оноо	60/40	0,4%





## АМБАССАДОР КЛУБД элсэхэд тавигдах шаардлагууд

Prouvé бизнесийн карьерын дараагийн нэг шат нь АМБАССАДОР КЛУБ юм. Таны амжилтын түвшин АМБАССАДОР-т хүрэхийн тулд таны багийн бүтцэд 21%-тай 1 партнертай байх ба бусад багийн эргэлтийн оноо нь хүснэгтэд заасан болзлыг хангасан байна. Танд олгогдох урамшуулал нь тухайн сарын Партнер Клубын болон Амбассадор клубын /харгалзах амжилтын цолны урамшуулал/ урамшууллуудын нийлбэр байна.

Багийн бүтцийн эргэлт/багийн оноо /сард/	Таны түвшин – Амбассадор Клубд тавигдах болзол	Таны амжилтын цол	
50,000 ба түүнээс дээш	<ol style="list-style-type: none"> <li>1) Таны багт хамгийн багадаа 21%-тай нэг партнер байх</li> <li>2) Таны бусад багууд таныг оролцуулаад 20,000 ба түүнээс дээш оноо цуглуулсан байх</li> <li>3) Таны хувийн худалдан авалтын оноо 50 ба түүнээс дээш байх</li> </ol>	<p>21% 20,000 оноо</p>	<p>Амбассадор 1 алтан ★</p>
80,000 ба түүнээс дээш	<ol style="list-style-type: none"> <li>1) Таны багт хамгийн багадаа 21%-тай хоёр партнер байх</li> <li>2) Таны бусад багууд таныг оролцуулаад 20,000 ба түүнээс дээш оноо цуглуулсан байх</li> <li>3) Таны хувийн худалдан авалтын оноо 50 ба түүнээс дээш байх</li> </ol>	<p>21% 21% 20,000 оноо</p>	<p>Амбассадор 2 алтан ★</p>
110,000 ба түүнээс дээш	<ol style="list-style-type: none"> <li>1) Таны багт хамгийн багадаа 21%-тай хоёр партнер байхаас гадна нэг амбассадор байх</li> <li>2) Таны хувийн худалдан авалтын оноо 50 ба түүнээс дээш байх</li> </ol>	<p>21% 21%</p>	<p>Амбассадор 3 алтан ★</p>
160,000 ба түүнээс дээш	<ol style="list-style-type: none"> <li>1) Таны багт хамгийн багадаа 21%-тай хоёр партнер байхаас гадна хоёр амбассадор байх</li> <li>2) Таны хувийн худалдан авалтын оноо 50 ба түүнээс дээш байх</li> </ol>	<p>21% 21%</p>	<p>Амбассадор 4 алтан ★</p>
250,000 ба түүнээс дээш	<ol style="list-style-type: none"> <li>1) Таны багт таван амбассадор байх</li> <li>2) Таны хувийн оноо хамгийн багадаа 50 оноо байх</li> </ol>		<p>Амбассадор 5 алтан ★</p>

## Амбассадор Клубын урамшууллыг бодох хүснэгт

Амбассадор Клубын эрхтэй болсон партнерууд Prouvé-ийн нийт онооны эргэлтийн 10%-ийг хувааж авдаг. Түвшин бүрд ногдох хувийг тодорхой харуулсан доорх хүснэгттэй танилцана уу.

Таны амжилтын цол	Тухайн сард болзол хангасан амбассадоруудад ногдох нийт онооны эргэлтийн хувь
Амбассадор 1 алтан* 	5%
Амбассадор 2 алтан* 	1,25%
Амбассадор 3 алтан* 	1,25%
Амбассадор 4 алтан* 	1,25%
Амбассадор 5 алтан* 	1,25%

Амбассадор Клубын урамшууллын систем нь тухайн сарын амжилтын түвшнөөс хамаарч нэмэгдэх зарчмаар явагддаг. Жишээ нь: 5 алтан \*той Амбассадор та зөвхөн өөрийн амжилтын цолны урамшууллыг хүртээд зогсохгүй мөн 1, 2, 3, ба 4 алтан \*той амбассадорын урамшууллыг нэмж авна.

### Хэрхэн ажилладаг вэ:




Багаараа хамтарч тоорт хийе гэж төсөөлье. Хийсэн тоортоо зөв хуваахын тулд торт хийхэд хэн илүү идэвхитэй оролцсон нь их хэмжээтэй авах нь шударга юм. Бидний урамшууллын систем үүнтэй адил. Тухайн сарын амжилтыг бүтээхэд хамгийн их оролцсон партнер хамгийн том хувийг хүртэнэ.



Урамшууллын бодолттой танилцана уу.

$$\frac{\text{Нийт эргэлтийн оноо} \times \text{Таны урамшууллын оноо}}{\text{Тухайн амжилтын түвшинд хүрсэн бүх партнеруудын урамшууллын оноо}}$$

Та урамшуулалд тооцох оноогоо дараах хүснэгтээс харна уу.

## АМБАССАДОР ЦОЛТНЫ БҮТЦИЙН ОНООГ ТООЦОХДОО:

Таны амжилтын түвшин	Тооцооллын зорилгоор 21% хүртэлх шууд спонсорлосон багийн оноо (Багт амбассадор байхгүй)	Хувийн оноо*	Багийн оноо: Таны багт хамгийн ихдээ 1 алтан* той амбассадор байх (ахлах эрхийг харна уу)	Багийн оноо: Таны багт хамгийн ихдээ 2 алтан* той амбассадор байх (ахлах эрхийг харна уу)	Багийн оноо: Таны багт хамгийн ихдээ 3 алтан* той амбассадор байх (ахлах эрхийг харна уу)	Багийн оноо: Таны багт хамгийн ихдээ 4 алтан* той амбассадор байх (ахлах эрхийг харна уу)	Багийн оноо: Таны багт 5 алтан* той амбассадор байх эсвэл аль нэгэн элит амбассадор байх (ахлах эрхийг харна уу)
Амбассадор 1 алтан* 	Бүгд	Бүгд	30,000 оноо	30,000 оноо	30,000 оноо	30,000 оноо	30,000 оноо
Амбассадор 2 алтан* 	Бүгд	Бүгд	Багийн нийт эргэлтээс хамаараад: 50,000 50,000–64,999.99 онооны эргэлтээс 60,000 65,000–79,999.99 онооны эргэлтээс 70,000 80,000 онооноос дээш	80,000 оноо	80,000 оноо	80,000 оноо	80,000 оноо
Амбассадор 3 алтан* 	Бүгд	Бүгд	Багийн нийт эргэлтээс хамаараад: 50,000 50,000–64,999.99 онооны эргэлтээс 60,000 65,000–79,999.99 онооны эргэлтээс 70,000 80,000 онооноос дээш	Багийн нийт эргэлтээс хамаараад: 80,000 80,000–99,999.99 онооны эргэлтийн дүнгээс 90,000 100,000–119,999.99 онооны эргэлтийн дүнгээс 100,000 120,000 онооноос дээш	110,000 оноо	110,000 оноо	110,000 оноо

Таны амжилтын түвшин	Тооцооллын зорилгоор 21% хүртэлх шууд спонсорлосон багийн оноо (Багт амбассадор байхгүй)	Хувийн оноо*	Багийн оноо: Таны багт хамгийн ихдээ 1 алтан* той амбассадор байх (ахлах эрхийг харна уу)	ГБагийн оноо: Таны багт хамгийн ихдээ 2 алтан* той амбассадор байх (ахлах эрхийг харна уу)	Багийн оноо: Таны багт хамгийн ихдээ 3 алтан* той амбассадор байх (ахлах эрхийг харна уу)	Багийн оноо: Таны багт хамгийн ихдээ 4 алтан* той амбассадор байх (ахлах эрхийг харна уу)	Багийн оноо: Таны багт 5 алтан* той амбассадор байх эсвэл аль нэгэн элит амбассадор байх (ахлах эрхийг харна уу)
Амбассадор 4 алтан* 	Бүгд	Бүгд	Багийн нийт эргэлтээс хамаараад: <b>50,000</b> 50,000–64,999.99 онооны эргэлтээс <b>60,000</b> 65,000–79,999.99 онооны эргэлтээс <b>70,000</b> 80,000 онооноос дээш	Багийн нийт эргэлтээс хамаараад: <b>80,000</b> 80,000–99,999.99 онооны эргэлтээс <b>90,000</b> 100,000–119,999.99 онооны эргэлтээс <b>100,000</b> 120,000 онооноос дээш	Багийн нийт эргэлтээс хамаараад: <b>110,000</b> 110,000–139,999.99 онооны эргэлтээс <b>125,000</b> 140,000–169,999.99 онооны эргэлтээс <b>140,000</b> 170,000 онооноос дээш	<b>160,000</b> оноо	<b>160,000</b> оноо
Амбассадор 5 алтан* 	Бүгд	Бүгд	Багийн нийт эргэлтээс хамаараад: <b>50,000</b> 50,000–64,999.99 онооны эргэлтээс <b>60,000</b> 65,000–79,999.99 онооны эргэлтээс <b>70,000</b> 80,000 онооноос дээш	Багийн нийт эргэлтээс хамаараад: <b>80,000</b> 80,000–99,999.99 онооны эргэлтээс <b>90,000</b> 100,000–119,999.99 онооны эргэлтээс <b>100,000</b> 120,000 онооноос дээш	Багийн нийт эргэлтээс хамаараад: <b>110,000</b> 110,000–139,999.99 онооны эргэлтээс <b>125,000</b> 140,000–169,999.99 онооны эргэлтээс <b>140,000</b> 170,000 онооноос дээш	Багийн нийт эргэлтээс хамаараад: <b>160,000</b> 160,000–219,999.99 онооны эргэлтээс <b>180,000</b> 220,000–279,999.99 онооны эргэлтээс <b>200,000</b> 280,000 онооноос дээш	<b>250,000</b> оноо

## ПАССИВ ОРЛОГОО ХЭРХЭН 2 ДАХИН НЭМЭГДҮҮЛЭХ ВЭ?



Та 5 алтан★той амбассадорын болзлыг ханган энэхүү амжилтаа 6 сарын турш хадгалж чадвал таныг 2 дахь партнерын дугаараар шагнах болно. Энэхүү шагналыг хамгийн идэвхтэй тасралтгүй хөгжсөн, амжилтаа тогтвортой хадгалсан амбассадорт олгодог юм. Энэ шагнал нь таны бүтцэд нэг баг нэмж Амбассадорын урамшууллыг нэмэгдүүлэхээс гадна Элит Амбассадор болох багийн бүтэц дэх тэнцвэрээ бий болгох боломжийг олгоно. Та өөрийн шагналын 2 дахь дугаараа багийн бүтцийнхээ дурын хэсэгтээ идэвхжүүлж болно.

## PROUVÉ БРЭНДИЙН АМБАССАДОР КЛУБЫН ДЭЛХИЙН НИЙТ ЭРГЭЛТИЙН (ДНЭ) НЭМЭЛТ УРАМШУУЛАЛ

1 алтан★той амбассадорын түвшинд хүрмэгц танд болон тухайн сард ижил түвшний болзлыг хангасан партнеруудад компанийн нийт онооны эргэлтийн 0.4%-ийг олгоно.

Энэхүү бонус нь мөн 2 алтан★, 3 алтан★, мөн 4 алтан★д ижил олгогдоно.







$$\text{Таны нэмэлт урамшуулал} = \frac{\text{Нийт эргэлтийн оноо} \times \text{Таны урамшууллын оноо} \times 0.4\%}{\text{Тухайн болзлыг хангасан партнеруудын нийт гэрээний оноо}}$$

Багийн бүтцийн эргэлт/багийн оноо /сард/	Таны амжилтын түвшин	Хувийн худалдан авалтын онооны доод хэмжээ /сард/	ДЭЛХИЙН ЭРГЭЛТИЙН ХУВЬ /Тухайн сард ижил түвшний болзол хангасан партнеруудад олгох нийт эргэлтийн онооны хувь/
50,000-аас дээш оноо	Амбассадор 1 алтан★	50 оноо	0,4%
80,000-аас дээш оноо	Амбассадор 2 алтан★	50 оноо	0,4%
110,000-аас дээш оноо	Амбассадор 3 алтан★	50 оноо	0,4%
160,000-аас дээш оноо	Амбассадор 4 алтан★	50 оноо	0,4%

Энэхүү урамшуулал нь таны тухайн сарын амжилтын дээд түвшинд олгогдоно. Жишээ нь: 3 алтан★той амбассадорын хувьд та тухайн цолны хувийг хүртэнэ. Энэхүү амбассадорын урамшууллыг хүртэж эхэлсэн бол Партнер Клубын ДНЭ-ийн урамшуулалд хамрагдахгүй.




## ЭЛИТ АМБАССАДОР КЛУБД тавигдах шаардлагууд

Таны багийн эргэлт 2,5 сая-аас дээш оноотой болж эхлэхэд таны карьерын дараагийн шинэ үе шат эхэлж та Элит Амбассадор Клубд орох эрхтэй болно. Энэ шатанд таны авах урамшуулал нь тухайн сарын болзол хангасан Партнер Клуб, Амбассадор Клуб болон Элит Амбассадор Клубын урамшууллаудын нийт дүнгийн нийлбэр байх болно.

Багийн бүтцийн эргэлт/багийн оноо /сард/	Таны түвшин – Элит Амбассадор болзол		Таны амжилтын түвшин
2,500,000-аас дээш оноо	<ol style="list-style-type: none"> <li>1) Алтан*той амбассадор цолтон 5 байх</li> <li>2) Хувийн худалдан авалтын оноо 50-аас дээш байх</li> <li>3) Багийн эргэлтийн оноо 2,500,000-аас дээш оноотой (хуваарилалт: бүтцийн хамгийн хүчтэй багийн дээд оноо 1,250,000 ба бүтцийн үлдсэн хэсэг нь 1,250,000-аас дээш оноотой байх; хэрэв хамгийн хүчтэй баг нь 1,250,000-аас бага оноотой бол бүтцийн нийт оноог авч үзэх ба бусад багууд нь 2,500,000 оноонд хүрэхүйц хангалттай оноотой байх шаардлагатай)</li> </ol>	 <p>1,250,000 оноо    1,250,000 оноо</p>	<p>Элит амбассадор 1 даймонд*</p> 
5,000,000-аас дээш оноо	<ol style="list-style-type: none"> <li>1) Алтан*той амбассадор цолтон 5 байх</li> <li>2) Хувийн худалдан авалтын оноо 50-аас дээш байх</li> <li>3) Багийн бүтцийн эргэлтийн оноо 5,000,000-аас дээш оноотой (хуваарилалт: бүтцийн хамгийн хүчтэй багийн дээд оноо 2,500,000 ба багийн үлдсэн хэсэг нь 2,500,000-аас дээш оноотой байх; хэрэв хамгийн хүчтэй баг нь 2,500,000-аас бага оноотой бол бүтцийн нийт оноог авч үзэх ба бусад багууд нь 5,000,000-д хүрэхүйц хангалттай оноотой байх шаардлагатай)</li> </ol>	 <p>2,500,000 оноо    2,500,000 оноо</p>	<p>Элит амбассадор 2 даймонд*</p> 
10,000,000 - аас дээш оноо	<p>Алтан*той амбассадор цолтон 5 байх</p> <ol style="list-style-type: none"> <li>1) Хувийн худалдан авалтын 50-аас дээш байх</li> <li>2) Багийн эргэлтийн оноо 10,000,000-аас дээш оноотой (хуваарилалт: бүтцийн хамгийн хүчтэй багийн дээд оноо 5,000,000 ба багийн үлдсэн хэсэг нь 5,000,000-аас дээш оноотой байх; хэрэв хамгийн хүчтэй баг нь 5,000,000-аас бага оноотой бол бүтцийн нийт оноог авч үзэх ба бусад багууд нь 10,000,000-д хүрэхүйц хангалттай оноотой байх шаардлагатай)</li> </ol>	 <p>5,000,000 оноо    5,000,000 оноо</p>	<p>Элит амбассадор 3 даймонд*</p> 

## Элит Амбассадор клубын урамшууллыг бодох хүснэгт

Элит Амбассадор Клубын болзол хангасан гишүүд Prouvé-ийн нийт эргэлтийн онооны 2.2%-ийг хувааж авдаг. Түвшин бүрт ногдох хувийг тодорхой харуулсан доорх хүснэгттэй танилцана уу.

Таны амжилтын түвшин	Тухайн сард болзол хангасан партнеруудад ноогдох нийт онооны эргэлтийн хувь
Элит амбассадор 1 даймонд★ 	0,6%
Элит амбассадор 2 даймонд★ 	0,6%
Элит амбассадор 3 даймонд★ 	1%

Элит Амбассадор Клубын урамшууллын систем нь тухайн амжилтын түвшнээс хамаарч нэмэгдэх зарчмаар явагддаг. Жишээ нь 3 даймонд★тай та зөвхөн өөрийн амжилтын цолны урамшууллыг хүртээд зогсохгүй мөн 1, 2, 3, 4, 5 алтан★той амбассадорын мөн 1 ба 2 даймонд★тай элит амбассадорын урамшууллыг нэмж авна.





Энэхүү урамшууллыг Амбассадор Клубын урамшууллын бодолттой адил томъёогоор бодно.

*Нийт эргэлтийн оноо х Таны урамшууллын оноо х Тухайн түвшний амжлтын хувь*

*Тухайн болзлыг хангасан партнеруудын нийт гэрээний оноо*

Элит Амбассадор Клубын бүтцийн оноог бодох арга нь өөр.


## ЭЛИТ АМБАССАДОРЫН БҮТЦИЙН ОНООГ ТООЦООЛОХДОО:

Таны амжилтын түвшин	Хамгийн хүчтэй багаас тооцох оноо	Бүтцийн бусад багуудын оноо. /Үүнд тооцоололд хамруулсан хувийн оноог мөн тооцно/
Элит амбассадор 1 даймонд * 	Эргэлтээс хамаарч: нийт багийн бүтцийн эргэлтийн оноо <b>1,250,000</b> -аас бага оноотой  1,250,000 оноо нь нийт багийн оноо нь 1,250,000-д хүрсэн үед	Бүгд
Элит амбассадор 2 даймонд * 	Эргэлтээс хамаарч: нийт багийн эргэлтийн оноо <b>2,500,000</b> -аас бага оноотой  2,500,000 оноо нь нийт багийн оноо нь 2,500,000 оноо хүрсэн үед	Бүгд
Элит амбассадор 3 даймонд * 	Эргэлтээс хамаарч: нийт багийн эргэлтийн оноо <b>5,000,000</b> -аас бага оноотой  5,000,000 оноо нь нийт багийн оноо нь 5,000,000 оноо хүрсэн үед	Бүгд

## Партнер Клубын урамшууллыг хэрхэн боддог вэ?

Энэ нь худалдан авсан бүтээгдэхүүний үндсэн оноогоор тооцогддог ба бүтээгдэхүүн тус бүрт өөр байна.

### 3%-ИЙН АМЖИЛТЫН ТҮВШИНТЭЙ ПАРТНЕРЫН УРАМШУУЛЛЫГ ТООЦОХ ЖИШЭЭ:



Таны үүсгэсэн бүтэц нийт 920 оноотой ба хувийн оноо 100 байна гэж бодъё. Хувийн болон бүтцийн онооны нийлбэр нь 1020 болсоноор та 3%-ийн амжилтын түвшинд хүрч, таны урамшуулал доорх хүснэгтийн дагуу тооцоолно. (1 оноо = 1,800₮ төгрөг)

Та болон таны багууд	Оноо	Амжилтын Түвшин	Таны болон таны багуудын амжилтын хувийн зөрүү	Үндсэн урамшуулал	
				Тооцоолол	Мөнгөн дүн ₮
Та	100	3%	—	$100 \times 3\% \times 1,800$	5,400
Батын багаас	100	0%	$3\% - 0\% = 3\%$	$100 \times 3\% \times 1,800$	5,400
Оюуны багаас	150	0%	$3\% - 0\% = 3\%$	$150 \times 3\% \times 1,800$	5,400
Төрөөгийн багаас	170	0%	$3\% - 0\% = 3\%$	$170 \times 3\% \times 1,800$	9,180
Жаргалын багаас	350	3%	$3\% - 3\% = 0\%$	$350 \times 0\% \times 1,800$	-
Доржийн багаас	150	0%	$3\% - 0\% = 3\%$	$150 \times 3\% \times 1,800$	8,100
Урамшуулал					36,180₮

#### Тодотгол:

Таны тухайн сарын үндсэн урамшуулал 36,180₮ байна. Танаас гадна Жаргал өөрийн багаасаа 18,900₮-ний урамшуулал авч байна.


#### Үнэт зөвлөгөө:

Та багийн эргэлтээ өсгөмөөр байна уу? Өөрийн багийнхандаа хэрхэн ажилладагаа хуваалцахаас гадна, тэдэнд үлгэрлэн харуулаарай. Тэд өөрсдөө хийж үзэх хэрэгтэй.



## 9%-ИЙН АМЖИЛТЫН ТҮВШИНТЭЙ ПАРТНЕРЫН УРАМШУУЛЛЫГ ТООЦОХ ЖИШЭЭ:

Дараагийн сард танай багийн бүтэц болон эргэлтийн оноо өссөн байна.



Таны багийн бүтцийн эргэлтийн нийт оноо 4,740 хүрсэнээр та 9%-ийн амжилтын түвшинтэй боллоо. Таны урамшууллын бодолтыг доорх хүснэгтээс харна уу.

Хувь хүн	Оноо	Амжилтын Түвшин	Таны болон таны багуудын амжилтын хувийн зөрүү	Үндсэн урамшуулал	
				Тооцоолол	Мөнгөн дүн ₮
Та	150	9%	—	150 x 9% * 1,800	24,300
Батын багаас	340	3%	9%-3%=6%	340 x 6% * 1,800	36,720
Оюуны багаас	250	0%	9%-0%=9%	250 x 9% * 1,800	40,500
Төрөөгийн багаас	1,050	3%	9%-3%=6%	1,050 x 6% * 1,800	113,400
Жаргалын багаас	2,000	6%	9%-6%=3%	2,000 x 3% * 1,800	108,000
Доржийн багаас	950	3%	9%-3%=6%	950 x 6% * 1,800	102,600
Урамшуулал					425,520₮

### Тодотгол:

Энэ сард таны үндсэн урамшуулалд хүрч та амжилттай ажиллаж, таны багийн бүтцийн бүх партнеруудад үндсэн урамшуулал тооцогдсон байна.

## 15%-ИЙН АМЖИЛТЫН ТҮВШИНТЭЙ ПАРТНЕРЫН УРАМШУУЛЛЫГ ТООЦОХ ЖИШЭЭ:

Та энэ сард багтайгаа илүү их хамтран ажилласанаар таны багийн бүтцийн нийт эргэлтийн оноо 18,500 хүрсэн байна.



15%-ийн амжилтын түвшинд таны урамшууллын тооцооллын жишээг дараах хүснэгтээр харууллаа.

Хувь хүн	Оноо	Амжилтын Түвшин	Таны болон таны багуудын амжилтын хувийн зөрүү	Үндсэн урамшуулал	
				Тооцоолол	Мөнгөн дүн ₮
Та	200	15%	—	$200 \times 15\% \times 1,800$	54,000
Батын багаас	3,150	6%	$15\% - 6\% = 9\%$	$3,150 \times 9\% \times 1,800$	510,300
Оюуны багаас	1,250	6%	$15\% - 6\% = 9\%$	$1,250 \times 9\% \times 1,800$	202,500
Төрөөгийн багаас	7,450	12%	$15\% - 12\% = 3\%$	$7,450 \times 3\% \times 1,800$	402,300
Жаргалын багаас	3,500	6%	$15\% - 6\% = 9\%$	$3,500 \times 9\% \times 1,800$	567,000
Доржийн багаас	2,950	6%	$15\% - 6\% = 9\%$	$2,950 \times 9\% \times 1,800$	477,900
Урамшуулал					2,214,000₮

### Тодотгол:

Таны үндсэн урамшууллын хэмжээ 2,214,000₮ болж өсчээ. Та 15%-ийн амжилтанд хүрсэн тул ДНЭ-ээс нэмэлт урамшуулал авах боломжтой боллоо. Мөн та багийн бүтцийн 60/40 харьцааг хангасан байна.

### Таны ДНЭ-ийн урамшууллыг тооцвол:


Таны нэмэлт урамшуулал=

Нийт эргэлтийн оноо  $\times 0.4\%$   $\times$  Таны багийн бүтцийн эргэлт

15%-ийн амжилтын түвшинд хүрсэн партнеруудын нийт бүтцийн эргэлт

## 21%-ИЙН ИЙН АМЖИЛТЫН ТҮВШИНТЭЙ ПАРТНЕРЫН УРАМШУУЛЛЫГ ТООЦОХ ЖИШЭЭ:

Цаг хугацаа явсаар, таны багийн бүтэц нь хурдтайгаар хөгжиж, идэвхтэй партнерууд илүү олон болохоос гадна та нэмж шинээр баг үүсгэсэн байна.



Таны бүтцийн нийт эргэлтийн оноо 44,630 энэхүү оноо нь таныг анх удаагаа 21%-ийн амжилтын түвшинд хүргэлээ. Энэ бол гайхалтай амжилт! 21% түвшин дэх таны урамшууллын тооцооллын жишээг дараах хүснэгтээр харуулав.

Хувь хүн	Оноо	Амжилтын Түвшин	Таны болон таны багуудын амжилтын хувийн зөрүү	Үндсэн урамшуулал	
				Тооцоолол	Мөнгөн дүн ₮
Та	230	21%	—	230 x 21% *1,800	86,940
Батын багаас	1,400	6%	21%-6%=15%	1,400 x 15% *1,800	378,000
Оюуны багаас	6,750	9%	21%-9%=12%	6,750 x 12% *1,800	1,458,000
Төрөөгийн багаас	21,000	18%	21%-18%=3%	21,000 x 3% *1,800	1,134,000
Жаргалын багаас	10,350	12%	21%-12%=9%	10,350 x 9% *1,800	1,676,700
Доржийн багаас	2,500	6%	21%-6%=15%	2,500 x 15% *1,800	675,000
Туяагийн багаас	2,400	6%	21%-6%=15%	2,400 x 15% *1,800	648,000
Урамшуулал					6,056,640₮

### Тодотгол:

Таны үндсэн урамшуулал 6,056,640₮ болтлоо өсжээ. Танд баяр хүргэе! Танай бүтцийн партнерууд мөн адил урамшууллаа авч чадсан байна. 21%-ийн амжилтын түвшинд хүрсэн мөн 60/40 харьцааг хангасан тул та ДНЭ-ийн нэмэлт урамшууллыг авна.


### Таны ДНЭ-ийн нэмэлт урамшууллыг тооцвол

$$\text{Таны нэмэлт урамшуулал} = \frac{\text{Нийт эргэлтийн оноо} \times 0.4\% \times \text{Таны багийн бүтцийн эргэлт}}{21\text{-ийн амжилтын түвшинд хүрсэн партнеруудын нийт бүтцийн эргэлт}}$$

# Амбассадор Клубын урамшууллыг хэрхэн боддог вэ?

## 1 АЛТАН★ТОЙ АМБАССАДОРЫН УРАМШУУЛЛЫН ТООЦООЛОЛ:

Танд баяр хүргэе! ТА 1 алтан★той амбассадор боллоо. Таны багийн бүтцэд төгс ажиллаж байгаа 3 баг байна. Мөн таны урамшуулал дараах 3 зүйлээс бүрдэх болно: Партнер Клубын урамшуулал, 1 алтан★той Амбассадор Клубын урамшуулал болон ДНЭ-ийн нэмэлт урамшуулал!



1 алтан★той амбассадорын урамшууллыг тооцоолохын тулд таны урамшуулал тооцох оноог гаргах хэрэгтэй.

1) 21% хүртэлх амжилтын түвшинтэй партнеруудын багийн оноонууд = 34,000 + 15,000 + 10,000 = 59,000 оноо

2) Хувийн худалдан авалтын оноо = 130 оноо

Таны урамшуулал тооцох оноо = 59,130 оноо

$$\text{Таны хүртэх \%} = \frac{\text{Таны урамшуулал тооцох оноо} \times 100\%}{\text{Нийт 1 алтан★той амбассадоруудын урамшууллын оноо}} \times 100\%$$

Таны урамшуулал = Таны урамшууллын оноо х Нийт эргэлтийн оноо х ДНЭ-ийн 5%

Та 1 алтан★той амбассадор болсон тул та ДНЭ-ийн эргэлтээс хувь хүртэх болно.

### Тодотгол:

Танд Партнер Клубын урамшуулал нэмэгдэнэ гэдгийг хэлэхэд таатай байна

### Таны ДНЭ-ийн нэмэлт урамшууллыг тооцвол:

$$\text{Таны нэмэлт урамшуулал} = \frac{\text{Нийт эргэлтийн оноо} \times 0.4\% \times \text{Таны урамшууллын оноо}}{1 \text{ алтан одтой амбассадор болзлыг хангасан партнеруудын нийт гэрээний оноо}}$$

### 3 АЛТАН★ТОЙ АМБАССАДОРЫН УРАМШУУЛЛЫН ТООЦООЛОЛ

Та багаа маш амжилттай хөгжүүлж байна. 3 алтан★той амбассадор болох үед таны урамшуулал хэрхэн тооцогдохыг дараах хүснэгтээс харна уу.



3 алтан★той амбассадор таны урамшууллыг тооцоолохын тулд таны урамшуулал тооцох оноог гаргах хэрэгтэй.

- 1) 21% хүртэлх амжилтын түвшинтэй партнеруудын багийн оноонууд = 32,000 + 31,000 + 9,000 = 72,000 оноо
  - 2) Хувийн худалдан авалтын оноо = 230 оноо
  - 3) 1 алтан★той амбассадорын болзлын оноо = 30,000 оноо
- Таны урамшуулал тооцох оноо = 102,230 оноо

$$\text{Таны хүртэх \%} = \frac{\text{Таны урамшууллын оноо}}{\text{Нийт 3 алтан★той амбассадоруудын урамшууллын оноо}} \times 100\%$$

Таны урамшуулал = Таны урамшууллын оноо x Нийт эргэлтийн оноо x 1,25%

Үүгээр ч зогсохгүй! 3 алтан★той амбассадор та ДНЭ-ийн урамшуулал хүртэх болно.

#### Таны ДНЭ-ийн нэмэлт урамшууллыг тооцвол:

#### Тодотгол:

Танд Партнер Клубын болон 1 алтан★ба 2 алтан★той Амбассадор Клубын урамшууллууд нэмэгдэнэ.


Таны нэмэлт урамшуулал =

Нийт эргэлтийн оноо x 0.4% x Таны урамшууллын оноо

3 алтан одтой амбассадор болзлыг хангасан партнеруудын нийт гэрээний оноо

## 5 АЛТАН★ТОЙ АМБАССАДОРЫН УРАМШУУЛЛЫН ТООЦООЛОЛ

Танд баяр хүргэе! 5 алтан★той амбассадор гэдэг бол ГАЙХАЛТАЙ АМЖИЛТ шүү!



5 алтан★той амбассадорын урамшууллыг тооцоолохын тулд бид таны урамшуулал тооцох оноог гаргах хэрэгтэй.

1) 21%-д хамааралтай бүлгийн оноонууд = 32,000 + 35,000 = 67,000 оноо

2) Хувийн худалдан авалтын оноо = 420 оноо

3) 1 алтан★той амбассадорын болзлын оноо = 60,000 + 50,000 + 60,000 + 60,000 = 230,000 оноо

1) 2 алтан★той амбассадорын болзлын оноо = 90,000 оноо  
 Таны урамшууллын оноо = 387,420 оноо

### Тодотгол:

Та Партнер Клубын болон 1 алтан★ ба 2 алтан★, 3 алтан★ ба 4 алтан★той Амбассадор Клубын урамшууллаа мөн нэмж авна.

$$\text{Таны хүртэх \%} = \frac{\text{Таны урамшууллын оноо}}{\text{Нийт 5 алтан★ той амбассадоруудын урамшууллын оноо}} \times 100\%$$


$$\text{Таны урамшуулал} = \text{Таны хүртэх \%} \times \text{Нийт эргэлтийн оноо} \times 1.25\%$$



## Элит Амбассадор Клубын урамшууллыг хэрхэн боддог вэ?

### 1 ДАЙМОНД★ТОЙ ЭЛИТ АМБАССАДОРЫН УРАМШУУЛЛЫН ТООЦООЛОЛ

Та улам өндөрт ниссээр! Танай багийн бүтцийн эргэлт 4,350,650 оноонд хүрлээ. Та 1 даймонд★той элит амбассадор цолд хүрлээ. Таны PROUVE бизнесийн орлогоос амжилтыг тань харж болно!



1 даймонд★той амбассадор таны урамшууллыг тооцоолохын тулд бид таны урамшуулал тооцох оноог гаргах хэрэгтэй.

- 1) Хамгийн хүчтэй багийн оноо = 2,000,000 оноо = 1,250,000 болзлын оноо
- 2) Үлдсэн бусад багийн оноо = 100,000 оноо + 1,000,000 оноо + 500,000 оноо + 750,000 оноо = 2,350,000 оноо
- 3) Хувийн худалдан авалтын оноо = 650 оноо

Таны урамшуулал тооцох оноо = 3,600,650 оноо

$$\text{Таны хүртэх \%} = \frac{\text{Таны урамшууллын оноо}}{\text{Нийт 1 даймонд одтой партнеруудын урамшууллын оноо}} \times 100\%$$

**Таны урамшуулал = Таны хүртэх % x Нийт эргэлтийн оноо x 0.6%**

#### Тодотгол:

Танд Партнер Клуб болон Амбассадор Клубын бүх урамшуулууд давхар тооцогдоно.

# „PROUVÉ” ГЭДЭГ ҮГИЙГ ХЭРХЭН ЗӨВ ХЭЛЭХ ВЭ?

Prouvé нь БАТЛАГДСАН гэсэн утгатай Франц үг юм. Дуудахад маш амархан “ПРҮҮ-ВЭ” гэж дуудаарай.

## ТОДОРХОЙЛОЛТ:

### Урамшууллын оноо

Багийн бүтцийн эргэлт болон бүтцийн тархацаас хамаарсан тухайн сарын оноо. Үүнд гэрээний оноо, хувийн худалдан авалтын оноо мөн шаардлагад заасан бусад оноо багтана. Урамшуулал тооцох оноог Амбассадор Клуб болон Элит Амбассадор Клуб дахь партнеруудын Prouvé орлогыг бодоход ашигладаг.

### Урамшууллын сан

Хувийн худалдан авалтын шаардлагатай оноог цуглууж чадаагүй тохиолдолд тухайн сард олгогдох байсан урамшууллын хуримтлал юм.

### Багийн бүтцийн гүний хэмжээ

Баг дахь спонсор болон партнер хоорондын зай. Багийн үе шат бүрт хязгааргүй гүний хэмжээтэй байж болох ба гүн бүтэц нь багийн тогтвортой байдлыг бий болгодог.

### Хувийн худалдан авалтын оноо

Өөрийн Партнер дугаар дээр Prouvé-ээс худалдаж авсан бүтээгдэхүүнд олгосон оноо.

### Амжилтын түвшин болон цол

Партнерын өөрийн болон багийн эргэлт, бүтэц, карьер төлөвлөгөөнөөс хамааран партнерт олгогдох амжилтын нэр

### Нэмэлт урамшуулал

15%, 18% ба 21% партнеруудын эсвэл 1 алтан★той, 2 алтан★той, 3 алтан★ба 4 алтан★той амбассадоруудын урамшуулалд нэмэгддэг нийт эргэлтийн онооны 2.8% хүртэлх хувь (заасан түвшин, цолд хүрсэн партнеруудад ДНЭ 0.4%) Энэхүү нэмэлт урамшууллыг хүртэхийн тулд та амжилтын тодорхой түвшинд хүрсэн байхаас гадна хувийн худалдан авалтын болзлыг хангаж, мөн таны багийн бүтэц 60/40 харьцааг барьсан байх шаардлагатай. (Зөвхөн 15%–21%-ийн амжилтын түвшинд хамаарна) Таны хүрч байсан амжилтын түвшин болон цолноос үл хамаарч зөвхөн тухайн сарын амжилтын түвшин цолны нэмэлт урамшууллыг авна.

### Баг

Бүтцийн гүний шинэ үеэс шинэ партнеруудтай эхэлж буй спонсор болон партнерууд. Бүтэц дэх багийн тоо нь бүтцийн тархцыг тодорхойлно. Аливаа бүтэц нь гүндээ болон өргөндөө хязгааргүй багтай байж болно.

### Багийн оноо

Календарын нэг сарын хугацаанд тухайн багийн нийт партнеруудын Prouvé-ээс худалдаж авсан бүтээгдэхүүнд олгосон онооны нийлбэр.

### Багийн эргэлтийн онооны болзол

Календарын нэг сарын хугацаанд тухайн багийн нийт партнеруудын Prouvé-ээс худалдаж авсан бүтээгдэхүүнд олгосон нийт оноо нь тухайн партнерын урамшуулалд хамрагдах шалгууруудын нэг болдог.

### Ахлах эрх

Гэрээний оноог тооцохдоо багийн тухайн сарын хамгийн өндөр цолтой партнерийг онцолно. Жишээ нь: Нэг багт 1 алтан★той болон 5 алтан★той амбассадоруудтай бол хамгийн өндөр цолтой буюу 5 алтан★тай амбассадор хичнээн бүтцийн хамгийн доод хэсэгт байсан ч бид түүнээс гэрээний оноог тооцдог.

## Спонсор

Гэрээн дээр спонсор хэмээн заагдсан партнер (Prouvé-тэй хамтран ажиллах шинэ партнерыг урьсан хүн)

## Бүтэц

Спонсорын багт байрлах нийт партнерууд.

## Бүтцийн эргэлт

Нэг сарын хугацаанд тухайн бүтцийн нийт партнеруудын Prouvé-ээс худалдаж авсан бүтээгдэхүүнд олгосон онооны нийлбэр дээр спонсорын оноог оролцуулан тооцно. Бүтцийн эргэлт нь тухайн партнерыг амжилтын аль түвшинд хүрэх эсэхийг тодорхойлдог.

## 60/40 харьцаа нөхцөл

Тухайн сард бүтцийн хамгийн өндөр оноотой багийн эргэлт нь бүтцийн нийт эргэлтийн 60%-аас хэтрээгүй байхыг шаардсан бүтцийн зөв хөгжлийг илэрхийлэх үзүүлэлт.

## Нийт эргэлтийн оноо

Календарын нэг сарын хугацаанд нийт партнеруудын Prouvé-ээс худалдаж авсан бүтээгдэхүүнд олгосон онооны нийлбэр.

## Гэрээний оноо

Тухайн сард Амбассадор Клубын өөрийн багтаа хамгийн багадаа 1 амбассадортой партнерт олгогдох оноо (энэ оноог бодохдоо ахлах эрхийг тооцдог) эсвэл Элит Амбассадор Клубын партнерт бүтцийн хөгжил өндөртэй, хүчтэй багтай эсэхээр нь шалгаруулж олгогдох оноо.

## Амжилтын нэмэлт урамшуулал

Тухайн улс оронд тусгайлан олгож байгаа нэмэлт урамшуулал. Бүтээгдэхүүн тус бүрт бүтээгдэхүүний онооноос гадна амжилтын нэмэлт урамшууллын оноо олгогбайдаг.

# УРАМШУУЛАЛ

## Урамшуулал болон түүнийг хэрхэн ашиглах вэ?

Prouvé-тэй хамтран ажилладаг партнерууд урамшууллаа ашиглах эрхийг эдэлнэ. Өөрөөр хэлбэл Prouvé-тэй хамтран ажилладаг партнерууд урамшуулалд хамрагдах эрхтэй байна.

## Урамшууллын талаар өөр юу мэдэх хэрэгтэй вэ?

Бүтээгдэхүүнийг шууд борлуулах болон сурталчилж буй партнер нь урамшуулал авах эрхтэй. Урамшуулал болон бусад мэдээллийг энэхүү Карьер төлөвлөлтөнд тайлбарласан байгаа. Урамшуулал нь тухайн сар дууссанаас хойш дараагийн сарын 10-ны дотор бодогдож тухайн бодогдсон сардаа олгогдоно. Бодогдсон урамшууллаа бүтээгдэхүүн захиалгадаа ашиглаж болох ба ашигласан дүнг хасаж үлдэгдэлийг мөнгөн хэлбэрээр олгоно.



PROUVÉ-ийн бүтээгдэхүүнийг доорх нэр бүхий түншийн тусламжтайгаар илүү сайн мэддэг боллоо.



**Холбоо барих:**

Улаанбаатар хот, 4-р хороо,  
Ази тауэр, 4-р давхар

Утас: 7707-6688

И-мэйл: [info@mn.prouve.com](mailto:info@mn.prouve.com)

**[www.mn.prouve.com](http://www.mn.prouve.com)**

 [facebook.com/Prouvé Mongolia/](https://facebook.com/Prouvé Mongolia/)  [instagram.com/prouve.mongolia.official/](https://instagram.com/prouve.mongolia.official/)